

# Э-Сонин

22 дахь дугаар



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2014 он 8 сар



“Монголын Хөрөнгийн  
Бирж” ТӨХК-ийн  
Гүйцэтгэх захирлын  
үүрэг гүйцэтгэгч  
Д.Ангарын мэндчилгээ



Санхүүгийн зохицуулах хорооноос  
гаргасан шийдвэрүүд



Засгийн газрын үнэт цаасны  
арилжааг Хөрөнгийн биржээр  
дамжуулахтай холбоотой бэлтгэл  
ажлуудыг хангаж байна



Үүсмэл санхүүгийн хэрэгслийг зах  
зээлд нэвтрүүлэх бэлтгэл ажлуудыг  
хангаж байна



“MSE ALL” нэгдсэн индексийг  
туршилтын журмаар зах зээлд  
нэвтрүүлж эхэллээ



МХБ-ийн “Бүртгэлийн журам”  
батлагдан, мөрдөгдөж эхэллээ



Монголын хөрөнгийн бирж мобайл  
Апплекейшнтэй болно

## Үйл явдлын хураангуй

- Лондонгийн Хөрөнгийн бирж группийн Гүйцэтгэх захирал Завиер Ролет баярын захидал ирүүллээ
- “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг шинэчлэн баталлаа
- Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангарыг ажлын хэсгийн ахлагчаар томиллоо
- Ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн хувьцаат компаниуд
- Ази, Номхон далайн орны хөрөнгийн биржүүдийн холбооны үндсэн гишүүний эрхийг сунгав
- Ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байна
- “Блүүмбэрг” компанийн төлөөллийг хүлээн авч уулзав
- Европын сэргээн босголтын банкттай хамтран ажиллах тухай.
- Кастодианы сургалтыг зохион байгууллаа
- Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох сургалт
- Компанийн нээлттэй танилцуулганд урьж байна

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 8-р сарын арилжааны мэдээ

### СУРГАЛТ

“Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох” сургалт 9 дүгээр сарын 22-ны өдөр эхэлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг Утас: 11-313747 /116 дугаараас авна уу.



**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Д.АНГАРЫН  
МЭНДЧИЛГЭЭ**

Э-Сонины шинэхэн дугаараараа дамжуулан Монголын хөрөнгийн биржийн үе үеийн удирдлагууд, Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн хамт олон, хамтран ажиллагч байгууллагууд, эрхэм уншигч Та бүхэндээ чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж, ажлын амжилт, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

Монгол Улсад хөрөнгийн зах зээл үүсч, хөрөнгийн бирж байгуулагдснаас хойш эдүгээ 23 жил өнгөрсөн байна. Улс орны хөгжил, бүтээн байгуулалтын хөтөч, хөрөнгө оруулалт, хөгжлийн түлхүүр нь хөрөнгийн зах зээл гэж үздэг. Манай хамт олон үнэт цаасны арилжааг дэлхий нийтийн жишиг хандлагын дагуу шударга, нээлттэй, ил тод, зохион байгуулах, олон улсын туршлагаас суралцах, мэдээллийн ил тод байдлыг хангах зарчмыг барин ажиллаж байгаа бөгөөд хөрөнгийн зах зээлийг төлөвшүүлэн хөгжүүлэх замаар Монгол орныхоо эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах зорилгыг өмнөө тавин ажиллаж байна.

Эрхэм уншигч Та бүхэндээ өөрсдийн явуулж буй бодлого, үйл ажиллагааны чиглэл, хөрөнгийн зах зээлийн бодит мэдээллийг Э-Сониноор дамжуулан хүргэх болно.

Монгол Улсад хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх үйлсэд мэргэжлийн байгууллагууд, үндэстний мэргэжилтнүүд, үнэт цаас гаргагчид идэвхи зүтгэл хүчин чармайлт гарган их хөгжил, их бүтээн байгуулалт, шинэчлэл өөрчлөлтийн төлөө хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.



**London**  
**STOCK EXCHANGE**

**ЛОНДОНГИЙН ХӨРӨНГИЙН БИРЖ ГРУППИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ЗАВИЕР РОЛЕТ БАЯРЫН  
ЗАХИДАЛ ИРҮҮЛЛЭЭ**

“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангарт Лондонгийн хөрөнгийн бирж группийн Гүйцэтгэх захирал Завиер Ролет шинэ албанд томилогдсонтой холбогдуулан баярын захидал ирүүлсэн. Тэрээр баярын захидалдаа Монголын хөрөнгийн зах зээлийг олон улсын санхүүгийн зах зээлд гаргах нь бидний хамтын ажиллагааны эрхэм зорилго юм гэдгийг онцлон тэмдэглээд цаашид хамтран ажиллахад таатай байх болно гэдгээ илэрхийлсэн.



**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”  
ТӨХК-ИЙН ТУЗ-ИЙГ ШИНЭЧЛЭН  
БАТАЛЛАА**



САНГИЙН ЯАМ

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 152 дугаар тогтоолоор “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг Сангийн яаманд шилжүүлсэн. Хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталлаа. Үүнд:

Дарга: Б.Нямаа, Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга

Гишүүдэд:

Б.Даажамба, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга

М.Батгэрэл, Төрийн өмчийн хорооны Бүтцийн өөрчлөлт, бодлогын хэрэгжүүлэх газрын дарга

Н.Энхбаяр, Уул уурхайн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын бодлогын хэлтсийн дарга

Б.Сүх-Очир, Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газрын Дотоод аудит, хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Н.Мөнхбат, Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирал



**МОНГОЛЫН ХӨРӨГИЙН БИРЖИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ Д.АНГАРЫГ АЖЛЫН  
ХЭСГИЙН АХЛАГЧААР ТОМИЛОО**

Төрийн өмчийн хорооны даргын 2014 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн А/155 дугаар тушаалаар Төрийн өмчийг 2014-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн бэлтгэл ажлуудын хүрээнд Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулсан бөгөөд тус ажлын хэсгийн ахлагчаар “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангарыг томиллоо.

Уг ажлын хэсгийн зорилго нь Төрийн өмчийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан үнэ цэнтэй, шудрага, шуурхай хувьчлах бэлтгэл ажлыг хангах, Төрийн өмчит зарим компаниудын санхүүгийн эрсдлийн удирдлагыг сайжруулах чиглэлээр санхүүгийн шинэ бүтээгдэхүүн бий болгох боломжуудын талаар санал дүгнэлт гаргахад чиглэгдсэн бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК, “ҮЦТТХТ” ТӨХК, МУЦАЭХолбооны төлөөлөл багтсан байна.



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ШИЙДВЭРҮҮД:

### ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОВ

“Экспонэйшнл Фанд Менежмент” ХХК,  
“БИ БИ СИ” ХХК-д хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгов.

### БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАВ

“Арилжаа импекс” ХК,  
“Борнуур” ХК,  
“Түшиг-уул” ХК,  
“Сүү” ХК-иудын үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулав.

### АРИЛЖААГ СЭРГЭЭВ

“Дэвшил мандал” ХК,  
“Баянбогд” ХК-иудын үнэт цаасны арилжааг сэргээв.

### ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОВ

“Лондон Азиа капитал Монголия” ХХК,  
“Санхүүгийн хөгжил инвест” ХХК  
“Рескап секьюритис” ХХК  
“Тэнь Ди Сек” ХХК,  
“НИКИ” ХХК,  
“Юу Жи Эс” ХХК,  
“Тэнгри Секуритиес” ХХК,  
“Мон Хан Трейд” ХХК-иудын Үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгов.

### БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА

“Ундррам Төв” ХК,  
“Дархан Импекс” ХК,  
“Хийц Увс” ХК,  
“Тэгш” ХК,  
“Алтан тариа” ХК-иудын үнэт цаасыг тус тус бүртгэлээс хассан шийдвэрүүдийг гаргажээ.

## НОГДОЛ АШИГ ТАРААХААР ШИЙДВЭРЛЭСЭН ХК-ИУД

“Хүрд” ХК,  
“Атар өргөө” ХК,  
“Ган хэрлэн” ХК,  
“Ээрмэл” ХК,  
“Улаанбаатар ЗБ” ХК,  
“Могойн гол” ХК,  
“Гутал” ХК,  
“Тээвэр Дархан” ХК,  
“Монгол алт” ХК,  
“Барилга корпораци” ХК,  
“Баянтээг” ХК,  
“Гермес центр” ХК,  
“Таван толгой” ХК-иуд ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн байна.



**АЗИ, НОМХОН ДАЛАЙН ОРНЫ ХӨРӨНГИЙН  
БИРЖҮҮДИЙН ХОЛБООНЫ ҮНДСЭН ГИШҮҮНИЙ ЭРХИЙГ  
СУНГАЛАА**



“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХКомпани нь 1998 оны 10 дугаар сарын 1-ний өдөр Евро-Азийн хөрөнгийн биржүүдийн холбоонд, 2008 оны 4 дүгээр сарын 10-нд Ази Номхон далайн орнуудын хөрөнгийн биржүүдийн холбоонд тус тус гишүүнээр элссэнээр бүс нутгийн томоохон Олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох, хамтран ажиллах боломж нээгдсэн түүхтэй. Энэ оны 7 дугаар сард Монголын хөрөнгийн биржийн Ази, Номхон далайн орны хөрөнгийн биржүүдийн холбооны үндсэн гишүүний эрхийг сунгалаа. Тус холбоо нь Австрали, Япон, Хонконг, Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг Ази, Номхон далайн 19 орны хөрөнгийн биржүүдийг эгнээндээ нэгтгэсэн бүс нутгийн хэмжээнд хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлд үйл ажиллагаа явуулж буй нэр хүндтэй байгууллагын нэг юм.



**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТАНИЛЦУУЛГА ХИЙЛЭЭ**

Компанийн засаглалыг сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах, компаниудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан мэдээг олон нийтэд мэдээллэх ажлыг Монголын хөрөнгийн бирж, Монголын хөрөнгийн зах зээлийн судалгаа хөгжлийн нийгэмлэг, гишүүн



брокер дилерийн компаниудтай хамтран уламжлал болгон зохион явуулахаар төлөвлөж байна. Тус ажлын хүрээнд “Говь” (MSE:GOV) ХК-ийн тайланг нээлттэй танилцуулсан бөгөөд арга хэмжээний үеэр “Стандарт Инвестмент”, “Гацуурт Трэйд”, “APS”, “Ард Капитал”, “Дархан Брокер”, “Таван Богд”, “Превалент”, “Монсек”, “Гаүли” зэрэг брокер дилерийн компанийн шинжээчид оролцож, сонирхсон асуултаа асууж дэлгэрэнгүй мэдээлэл авч чадсан үр өгөөжтэй ажил болсон.

Иргэд ТА бүхэн “Говь” ХК-ийн талаарх танилцуулга, мэдээг Брокер, дилерийн компаниар дамжуулан авах боломжтой.



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ "MSE ALL" НЭГДСЭН ИНДЕКСИЙГ ТУРШИЛТЫН ЖУРМААР ТООЦОЖ ЭХЭЛЛЭЭ

Хувьцааны зах зээлийн бодит чиг хандлагыг илэрхийлэх зорилгоор 2014 оны 7-р сарын 28-ны өдрөөс эхлэн "MSE ALL" нэгдсэн индексийг туршилтын журмаар 1000 нэгжээс тооцож эхлээд байна. "MSE ALL" нэгдсэн индекс нь олон нийтэд нээлттэй арилжигдаж байгаа бүх хувьцаат компанийг хамруулсан индекс бөгөөд хувьцаа цөөн тоогоор арилжигдаж ханшийг огцом хөдөлгөх байдлыг бууруулах, зах зээлийн үнэлгээ өндөр компанийн индекст нөлөөлөх нөлөөллийг тэнцвэржүүлэх зорилготой шинэчилсэн аргачлалыг ашиглан тооцож байгаа юм.

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ МОБАЙЛ АППЛЕКЕЙШТАЙ БОЛНО



Монголын хөрөнгийн бирж нь өдөр тутмын арилжаа болон ханшийн мэдээллээ мобайл апплейкешны тусламжтайгаар олон нийтэд хүргэх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

Энэхүү апплейкешн нь хэрэглэгчдэд тухайн өдрийн индексүүд болон арилжааны мэдээг бодит цагийн горимоор шууд хүргэх юм. Мөн хэрэглэгч өөрийн сонирхсон үнэт цааснуудаар багц үүсгэх, ханш ихээр хэлбэлзэх тохиолдолд дохио өгөх зэрэг давуу талуудтай байх юм.

Энэхүү шинэ бүтээгдэхүүнийг Монголын Хөрөнгийн Бирж өөрсдийн дотоод нөөц боломжийг ашиглан хийж гүйцэтгэн энэ оны 10 дугаар сараас эхлэн AppStore-д байршуулахаар төлөвлөж байна.

## АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮНЭЭР "МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Д.АНГАР



ЭРДЭС БАЯЛАГ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын 2014 оны 18 дугаар тогтоолоор баталсан Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, эрдэс баялгийн бирж байгуулах, түүнчлэн экспортын нэг цонхны зарчмаар үйл ажиллагаа явуулах, хууль зүйн орчин бүрдүүлэх тухай санал дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан бөгөөд тус ажлын хэсгийн гишүүнээр "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангар ажиллаж байна.



## САНГИЙН ЯАМ

### САНГИЙН ЯАМНААС ХӨРӨНГИЙН БИРЖИД ЧИГЛЭЛ ӨГЛӨӨ

Өмнө нь Хөрөнгийн биржээр дамжин хийгддэг байсан Засгийн газрын үнэт цаасны арилжааг 2012 оноос эхлэн Монголбанкинд шилжүүлсэн байна. Харин УИХ-ын 2013 оны 41 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2014 оны 7 дугаар сарын 30-ны өдөр Сангийн яамнаас Хөрөнгийн биржид үүрэг өгсөн байна. Энэхүү үүрэг даалгаварт Засгийн газрын үнэт цаасны арилжааг Хөрөнгийн биржээр дамжуулахад зах зээлд оролцогч байгууллагууд бэлтгэгдсэн эсэх, програм хангамж, клиринг, төлбөр тооцоо, тайлан бүртгэлийг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэх боломжтой эсэхэд судалгаа хийж ойрын хугацаанд эргэн танилцуулахыг Хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д. Ангарт даалгасан байна.



### МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН "БҮРТГЭЛИЙН ЖУРАМ" БАТЛАГДАН, МӨРДӨГДӨЖ ЭХЭЛЛЭЭ

МХБ-ийн "Бүртгэлийн журам" батлагдан, мөрдөж эхэллээ. Энэхүү журмын шинэчилсэн найруулгаар гадаадад бүртгэлтэй хуулийн этгээд Монголын хөрөнгийн биржид үнэт цаас гаргах, Монголд бүртгэлтэй компани гадаад улсад үнэт цаас гаргах буюу давхар бүртгэл хийлгэх, хувьцааны бүртгэлийн I, II, III гэсэн 3 ангилал, бүртгэлтэй компаниудын тогтмол биелүүлэх үүрэг буюу мэдээллийн ил тод байдлыг хангах, компанийн засаглалын зарчмыг дагаж мөрдөх талаар нэмэлт асуудлуудыг зохицуулж өгсөн бөгөөд бүртгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг олон улсын жишигт нийцүүлээд байна. Түүнчлэн МХБ-д үнэт цаас бүртгүүлэн арилжих ажиллагаа хялбарших ба биржид төлөх төлбөр, хураамжийн хэмжээ буурахаас гадна шинээр III ангилал бий болгосноор жижиг, дунд бизнес эрхлэгчдэд хөрөнгийн зах зээлээс санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэх боломжийг нээж өгч байна.

Түүнчлэн бид "Үнэт цаасны арилжааны хяналтын журам", "Гишүүнчлэлийн журам"-уудыг шинэчлэн батлуулахаар зохих судалгааг хийж, журмын төслүүдийг бэлтгэн мэргэжлийн оролцогчид болон зохицуулах дээд байгууллагуудын саналыг тусгах зорилгоор хүргүүлээд байна. Эдгээр журмаар гишүүн компаниудад тавих хяналт болон үнэт цаасны арилжааны хяналтын систем сайжрах, гишүүдийн чадавхийг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах зэрэг зохицуулалт хийгдсэн.





## БЛҮҮМБЭРГ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА.

BLOOMBERG TERMINAL

Засгийн газрын үнэт цаасны арилжааг Хөрөнгийн биржээр дамжуулах бэлтгэл ажлын хүрээнд тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг Блүүмбэрг терминал ашиглан явуулах талаар судалж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангар 2014 оны 8 дугаар сарын 4-ний өдөр Блүүмберг компанийн Азийн санхүүгийн зах зээл хариуцсан төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.



Тус уулзалтаар Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг “Блүүмберг Терминал” электрон арилжааны системийг ашиглан явуулах асуудлаар дэлгэрэнгүй санал солилцлоо.

Дашрамд дурьдахад “Блүүмберг Терминал” электрон арилжааны системийг Их Британи, Швед, Бельги, Өмнөд Африк, Финланд, Гүрж зэрэг орнууд ашиглаж байна.



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖЭЭР ВАЛЮТЫН ФЬЮЧЕРС, ОПЦИОН ГЭРЭЭ АРИЛЖААЛАГДАНА

Монголын хөрөнгийн биржээс “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжаалах журмыг боловсруулах, зах зээлд шинэ бүтээгдэхүүн

нэвтрүүлэх зорилгоор ажлын хэсэг гарган ажиллаж байна.

Үүсмэл санхүүгийн хэрэгслийг дотоодын зах зээлд нэвтрүүлснээр иргэд, аж ахуйн нэгж, компани болон хөрөнгө оруулагчид санхүүгийн эрсдэлээ зохистой удирдах боломжтой болох юм. Монголын хөрөнгийн биржийн зүгээс эхний ээлжинд валютын фьючерсийг арилжиж эхлэхээр төлөвлөж байгаа ба бараа бүтээгдэхүүнд суурилсан өөр бусад хэрэгслийг нэвтрүүлэх чиглэлээр мөн судалгааны ажил хийгдэж байна.



## Custody training

## ЛОНДОНГИЙН ХӨРӨНГИЙН БИРЖТЭЙ ХАМТРАН КАСТОДИАНЫ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

“Үнэт цаасны зах зээлийн тухай хууль” болон холбогдох журам батлагдан гарсантай холбогдуулан Кастодианы үйл ажиллагааг дотоодын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд банкны мэргэжилтнүүдэд тусгайлан зориулсан “Кастодианы үйл ажиллагааны ахисан түвшний сургалт”-ыг 2014 оны 8 дугаар сарын 6-7-ны өдрүүдэд зохион явуулж нийт суралцагчдаас сорилын шалгалт авч, сургалт амжилттай өндөрлөлөө.

Сургалтыг кастодианы чиглэлээр 30 гаруй жил ажилласан дадлага туршлагатай Лондонгийн хөрөнгийн бирж группийн ахлах зөвлөх Брюс Лоренс удирдан явуулсан.

Кастодианы үйл ажиллагааг Монгол Улсад эрхлэн явуулахад тулгарч болох аливаа эрсдэл, хүндрэл бэрхшээлүүд, олон улсын хөрөнгө оруулагчдын зүгээс бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих нөхцөл, шаардлагын талаар сургалтаар мэдээллийг олгож, зөвлөгөө зааварчилгааг дэлгэрэнгүй өглөө.



**European Bank**  
for Reconstruction and Development

## ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ ХӨГЖЛИЙН БАНКТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ САНАЛ СОЛИЛЦОО

“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангар Европын сэргээн босголт хөгжлийн банкны суурин төлөөлөгчийн орлогч Ө.Азжаргалтай уулзаж, Монголын хөрөнгийн зах зээлийн ирээдүйн хөгжлийн талаар санал солилцлоо.

Уулзалтын үеэр Монголын хөрөнгийн биржийн зүгээс Европын сэргээн босголт хөгжлийн банктай Монголын хөрөнгийн зах зээлээс бүтээгдэхүүн худалдан авах, цаашлаад өөрийн эзэмшиж буй хувьцааг тус зах зээлд гаргах боломжийн талаар судалж хамтран ажиллахыг санал болголоо.



Өнөөдрийн байдлаар ЕСБХБанк нь Монгол улсад 1.0 тэрбум орчим ам.долларын хөрөнгө оруулалт хийгээд байна.

## АНХАН ШАТНЫ МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТ

Монголын хөрөнгийн биржээс иргэд, хөрөнгө оруулагчдыг үр ашигтай хөрөнгө оруулалт хийх, идэвхтэй хариуцлагатай үнэт цаас эзэмшигч болгох, нийгмийн баялагаас шударгаар хувь хүртэх, амьжиргаагаа дээшлүүлэх боломжтой болгоход нь туслах зорилгоор тэдгээрийг Үнэт цаасны зах зээлд сургах, өргөнөөр оруулцуулахад зориулсан сургалтыг 2005 оноос хойш өнөөдрийг хүртэл зохион явуулж ирсэн бөгөөд 9 жилийн хугацаанд 3000 гаруй иргэд сургалтанд идэвхтэй хамрагдсан байна.

Үнэт цаас, хөрөнгийн зах зээлийг сонирхогч иргэдийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаа нь нийгмийн эрэлт хэрэгцээ их байгаагийн илрэл юм.

Өөртөө Оюуны хөрөнгө оруулалт хийхээр зорьж байгаа оюутан залуус, хөрөнгийн зах зээлийг сонирхогч нийт иргэддээ хөрөнгийн зах зээлийн боловсролоо дээшлүүлэх үйлсэд Тань амжилт хүсье.





2014 оны 8 дугаар сар


**Арилжааны товч мэдээ**

Арилжигдсан ширхэг	4,190,618
Нийт үнийн дүн /төг/	902,749,620
Хэлцлийн тоо	714
Арилжигдсан үнэт цаасны тоо	61
Зах зээлийн үнэлгээ /төг/	1,625,530,754,734

**ТОП-20 индекс**

Хаалт	15,896.09
Өмнөх сарын хаалт	15,871.73
Өөрчлөлт /нэгж/	24.36
Өөрчлөлт /%/	0.15
52 долоо хоног дээд	17,160.49
доод	13,422.43

**ТОП 20 ИНДЕКС**



**Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:**

Тоо ширхэгээр:

Үнийн дүнгээр:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн
1	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	3 575 989	321,549,210.0	1	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	3 575 898	321,549,210.0
2	MDR	МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ	227 715	137,026,442.0	2	MDR	МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ	227 715	137,026,442.0
3	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	169 742	100,818,790.0	3	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	169 742	100,818,790.0
4	OLL	ОЛЛОО	32 113	3,853,674.0	4	GOV	ГОВЬ	11 848	91,936,515.0
5	RMC	РЕМИКОН	27 829	4,185,540.0	5	TTL	ТАВАН ТОЛГОЙ	18 028	90,384,015.0

**Хамгийн их өсөлттэй үнэт цаас:**

№	Симбол	Үнэт цаасны нэр	Өмнөх сарын хаалт	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					төгрөг	%
1	NKT	НАКО ТУЛШ	274.94	360.0	85	30.94
2	DHU	ДАРХАН ХҮНС	4,000.0	5,140.0	1,140	28.50
3	AOI	АВТО ИМПЕКС	3,000.0	3,700.0	700	23.33
4	NEH	ДАРХАН НЭХИЙ	15,890.0	19,460.0	3,570	22.47
5	MBG	МОН-ИТ БУЛИГААР	6,200.0	7,500.0	1,300	20.97

**Хамгийн их бууралттай үнэт цаас:**

№	Симбол	Үнэт цаасны нэр	Өмнөх сарын хаалт	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					төгрөг	%
1	SOR	СОР	2,644.0	2,000.0	-644	-24.36
2	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	1,800.0	1,451.0	-349	-19.39
3	BTG	БАЯН ТЭЭГ	25,720.0	21,880.0	-3,840	-14.93
4	ETR	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	114.0	99.0	-15	-13.16
5	NXE	НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ	1,800.0	1,600.0	-200	-11.11